



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 654

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 62,684,704.00 (жаран хоёр сая зургаан зуун наян дөрвөн мянга долоон зуун дөрвөн) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 35,000,000.00 (гучин таван сая) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга, Бригадын генерал Д.Ариунболдод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2022 оны 6 дугаар сарын 27 ны өдрийн
 653 дугаар тогтоолын хавсралт

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
 АШИГЛАХ ХУГАЦАА, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Үйлдвэрлэсэн /ашиглалтад/ орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл/ төгрөг/	Цаашид ашиглах хугацаа /жил/	Шинэчлэн тогтоосон үнэ /төгрөг/
1	Суудлын автомашин TOYOTO LAND CRUISER J200 JTMHU09J104058291 , улсын дугаар 3607 УНХ	2012/2012	262,451	62,684,704.00	3	35,000,000.00
	НИЙТ ҮНЭ			62,684,704.00 (жаран хоёр сая зургаан зуун наян дөрвөн мянга долоон зуун дөрвөн төгрөг)		35,000,000.00 (гучин таван сая)